



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2010/06

Огноо: 2010 оны 6-р сарын 17

Эмбарго: 2010 оны 6-р сарын 18-ны Баасан гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн Захирлуудын зөвлөлийн хурлаас бодлогын хүүг 11% хувь дээр хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Улаанбаатар хотын ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци энэ оны 5-р сарын байдлаар сарын 4.2%, оны эхнээс 16.1%, жилийн 11.7%-тай гарсан нь ихээхэн өндөр үзүүлэлт юм. 2010 оны 1-р улирлаас хурдацтай нэмэгдэж буй инфляцийг үндсэндээ махны үнэ тодорхойлж байсан бол цаашид эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэх төлөвтэй байна. Банкны системийн зээл олголт нэмэгдэж, хувийн сектор идэвхжиж байгаа үед батлагдахаар хүлээгдэж буй 2010 оны төсвийн тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн зардал ихээхэн нэмэгдэж, хөрөнгө оруулалтаас илүү хэрэглээг түлхүү дэмжих хандлагатай байгаа нь эрэлтийн хүчин зүйлсээр бий болох инфляцийг нэмэгдүүлэхээр байна. Монголбанк төсвийн зардлаас гадна инфляцид нөлөөлөх эрэлтийн хүчин зүйл болох хувийн секторын идэвхжил, зээлийн өсөлт зэргийг анхааралтай ажиглах болно.

Инфляцийн дарамт ийнхүү нэмэгдэхээр байгаа нь хүн амын бодит орлогыг бууруулж улмаар дунд, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг сааруулдаг үндсэн хүчин зүйлсийн нэг тул Төв банк ойрын хугацаанд мөнгөний бодлогыг дахин чангаруулах нөхцөлтэй тулгарч болзошгүй байна. Ийнхүү төсвийн тэлэлт, түүнд хариу үзүүлсэн мөнгөний бодлогын чангаралт нь хувийн секторын хөгжил, хөрөнгө оруулалтыг хумиж, дунд болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлтэй гэдгийг Монголбанк анхааруулж байна.

Цаашид мөнгөний бодлогыг чангаруулах эсэх нь 2010 оны төсвийн тодотгол, түүний дунд хугацааны төсөөлөл хэрхэн батлагдахаас шууд хамаарна.

МОНГОЛБАНК